



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Говь-Сүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 10 нэрийн, нийт 13,945,827.80 (арван гурван сая есөн зуун дөчин таван мянга найман зуун хорин долоон төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,906,248.74 (нэг сая есөн зуун зургаан мянга хоёр зуун дөчин найман төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2022 оны ... дугаар сарын-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ГОВЬ-СҮМБЭР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮНЭ БОЛОН АШИГЛАХ ХУГАЦААГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон, шинэчлэн тогтоосон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Тоо хэм жээ	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		
					Нэг бүрийн үнэ (үнэ)	Нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Сандаал /төсөл сургалт 2021/	9/30/2021	1,008,307.32	6	50,415.37	302,492.20	2
2	Шилэн хаалга шүүгээ /ммс 2021/	9/30/2021	305,000.00	1	152,500.00	152,500.00	3
3	Компьютер /2009/	1/1/2011	2,827,198.00	2	141,359.90	282,719.80	1
4	Сүлжээний тоног техөөрөмж /ГТ ИБТ \DEL260/	1/1/2011	940,022.48	1	282,006.74	282,006.74	2
5	Зургийн аппарат /Canon-1200 D/	10/3/2016	1,450,000.00	1	145,000.00	145,000.00	1
6	Зургийн аппарат /1300 D/	2/25/2019	2,860,000.00	2	143,000.00	286,000.00	1
7	Принтер /samsung sc-3200/	12/31/2010	399,000.00	2	19,950.00	39,900.00	1

8	Принтер /samsung sc-1660, ИБ/	8/12/2010	891,000.00	3	29,700.00	89,100.00	1
9	Хэвлэгч	12/31/2014	2,076,300.00	1	207,630.00	207,630.00	1
10	Зургийн аппарат /1300 D/	4/10/2017	1,189,000.00	1	118,900.00	118,900.00	1
			13,945,827.80 (арван гурван сая есөн зуун дөчин таван мянга найман зуун хорин долоон төгрөг наян мөнгө)			1,906,248.74 (нэг сая есөн зуун зургаан мянга хоёр зуун дөчин найман төгрөг далан дөрвөн)	